

4

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БА ХАМТАРСАН УУЛ УУРХАЙН КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ОЛОН НИЙТИЙН БОДОЛ САНАЛ

С.Алтанцэцэг , Ж.Сарантуяа

Азийн Судалгааны Төвөөс Санхүүжүүлэв.

“Perception of Community on Corporate Social Responsibility of Foreign and Joint Mining Companies”

Удиртгал

Судалгаа нь компанийн нийгмийн хариуцлагын талаархи онол, одоогоор тус улсад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компанийн өнөөгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан уул уурхайн нийгмийн хариуцлагын талаархи олон нийтийн санал бодлыг судалсан болно.

Судалгааг явуулахдаа 600 хүнийг оролцуулсан санал асуулга авч, сонгон авсан компанийн жишээн дээр харьцуулалт хийх байдлаар гүйцэтгэсэн. Олдоц муутай буюу олон нийтэд хүртээгүй мэдээлэл болон нэмэгдэл мэдээлэл авах зорилгоор зарим нэг компанийн хүний нөөцийн алба, олон нийттэй харилцах албаны ажилтнуудтай уулзаж ярилцлага хийсэн.

Судалгаанаас үзэхэд компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг нэвтрүүлж байгаа төдийгүй компанийн хөгжил, өсөлтөд чухал ач холбогдолтойг ойлгож эхэлсэн нь харагдаж байна. Компани, олон нийт нийгмийн үүрэг хариуцлагын талаар нилээд зөрөөтэй ойлголттой байна. Зарим тохиолдолд компанийн санал бодол, олон нийтийн санал бодолтой зөрчилдөж байна.

I. СУДАЛГААНЫ АСУУДАЛ

Хөгжиж буй орнуудад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын асуудал түүхийн олон зуун жилийн туршид төвөгтэй асуудал байсаар иржээ. Харин даяаршилын энэ үед компаниуд нийгмийн хариуцлагын төлөвлөгөө боловсруулж, бизнесийн стратегийн өлөвлөгөөнийхөө нэг хэсэг хэмээн үзэх болсон юм. Компаниуд орон нутгийн иргэдэд ажил олгох, татвар төлөх, үйлдвэрлэлийн байгууламж бүтээх, үр ашгаа нэмэгдүүлэх, технологи нэвтрүүлэх зэрэг олон арга хэмжээ авч байна. Гэсэн хэдий ч орлогын ялгаа, хөдөлмөрийн нөхцөл, авилга хээл хахууль, байгаль орчны бохирдол, эрүүл ахуй аюулгүй байдал, хүний эрх гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх шаардлага байгаа юм.

Компанийн нийгмийн хариуцлагын асуудал даяаршил, зах зээл ашгийн төлөөх өрсөлдөөн, байгаль орчныг хамгаалах иргэний нийгмийн хөдөлгөөн зэрээс үүдэн маш чухал асуудал болжээ. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нийгэмд хандсан үйл ажиллагаагаа нэмэгдүүлж, олон нийтийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулж, орон нутгийн хөгжил, ажилчдынхаа болон тэдний гэр бүлд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Цаашид уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд уул уурхайг тойрсон асуудлууд, тухайлбал хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, уул уурхайгаас олох орлогыг хуваарилах, орлогын хуваарилалтад хяналт тавих, засаглалын ил тод байдлыг хангах, байгаль орчинд ивээлтэй уул уурхайг хөгжүүлэх, орон нутгийг хөгжүүлэх, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх гэх мэт маш олон асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах шаардлагатай байгаа юм.

Засгийн газрын зүгээс ч эдийн засаг нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндэсний бодлогын хүрээнд компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг тавих болжээ. Монгол улсын засгийн газрын хувьд ч уг бодлого гадаадын хөрөнгө оруулалтын стратегийн нэг хэсэг болж байгаа билээ.

Гэтэл компанийн Засгийн газрын өмнө хүлээсэн нийгмийн хариуцлага, бүс нутгийн болон орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр үүргийн талаар төдийлөн судалгаа хийгдээгүй явсаар ирсэн байна. Одоогоор хийгдээд байгаа судалгааны ажлууд хувийн салбарын хөгжил, гадаадын шууд хөрөнгө оруулалт ба түүний Монголын эдийн засгийн хөгжилд гүйцэтгэж буй үүргийг судлаж иржээ.

Одоогоор Монголд уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын талаархи олон нийтийн үзэл бодлыг харуулсан тоймтой судалгаа хийгдээгүй байгаа нь харагдлаа.


II. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАР

Дэлхийн уул уурхайн салбар хөгжлийн шинэ хэлбэрт шилжиж байгаа бөгөөд энэ нь өөрийн үйл ажиллагаагаа хөгжиж буй орны уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт нилээн нээлттэй болсон, үйлдвэрлэлийн шинэ технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах шаардлага зэрэг гадаад орчинд гарч буй өөрчлөлтөөс шалтгаалж байгаа юм.

Энэхүү технологийн болон үйл ажиллагааны өөрчлөлтийг зөв оновчтой удирдах юм бол хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжил, байгаль орчны хамгаалалтад эерэг нөлөө үзүүлэх юм.

Монгол улсын уул уурхайн салбар нь гадаадын хөрөнгө оруулалтын 61 хувийг эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүн үндэсний аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 хувь, гадаад экспортын орлогын 78 хувь, ДНБ-ний 30 гаруй хувийг эзэлдэг билээ.

График 1 Уул уурхайн эдийн засагт оруулах хувь нэмэр




Эх сурвалж: <http://www.miningmongolia.mn>

БНХАУ уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч хамгийн том улс бөгөөд Канад, БНСУ, Япон, АНУ үүний дараа орж байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2006 онд 53600 хүрсэн бөгөөд уул уурхайн салбарт 2006 онд 16167 хүн ажилласан байна. (Үйлдвэрлэл, худалдааны яам, 2006, х. 11-13; Үндэсний статистикийн газар, 2006, х. 53, 71).

Metals Economics Group-ийн мэдээлсэнээр 2004-2006 онуудад Монгол улсад хийгдсэн хайгуулын зардал нь дэлхийн хайгуулын нийт зардлын 4 хувьтай тэнцэж байсан бөгөөд энэ нь манай улсыг геологи хайгуулын дэлхийн 10 том орны нэгийн эгнээнд оруулж байна.

График 2. Хайгуулын үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт



Эх сурвалж: <http://www.miningmongolia.mn>

2005-2006 онд хайгуулын хөрөнгө оруулалт 200 сая төгрөг буюу 180 сая долларт хүрсэнээр 2 дахин өссөн байна. Хөрөнгө оруулалтын дийлэнхи нь алт, зэс, уран, нүүрс, жоншны хайгуулд оржээ.

Монгол улсын эрдэс баялагийн нөөц асар их ирээдүйд тооцогдож байгаа нь доорхи статистик үзүүлэлтээс харагдаж байна. Үүнд:

- 80 төрлийн эрдэс баялагийн 6,000 гаруй орд нээжээ. Үүнээс хамгийн том нь 2001 онд нээсэн Оюу толгойн зэс/алтны орд юм.
- 400 ордоос 160 гаруй нь үйлдвэрлэлийн зорилгоор ашиглаж эхлээд байна
- 170 барилгын материалын түүхий эдийн ордыг судалж үзээд байгаа ба үүнээс 35-ыг нь үйлдвэрлэлд ашиглаж байна. Түнчлэн, 90 ордыг ашиглахаар төлөвлөөд байна.


- (www.fifta.org.mn)
- 2009 оны 1-р сарын 2-ны байдлаар уул уурхайн салбарт 5202 хайгуул, олборлолтын ын лиценз олгожээ. (В. Bulgamaa, 31 percent of Mongolian Territory Has Been Issued Mining Licenses UB Post, 5 February 2009)

Монгол улсын нутаг дэвсгэрт 680 эрдэс баялгийн орд байгаа бөгөөд үүнд нүүрс, зэс, алт, уран, төмрийн хүдэр, мөнгө, цайр, жонш, вольфрам багтаж байна. Таван толгойн орд нь 100 – 150 тэр бум тон нүүрсний нөөцтэй гэсэн тооцоо гарсан юм.

Ураны олборлолтын хувьд Монгол улс дэлхийд ОХУ-ын дараа 2-р байр эзэлж байна. Харин хайгууль хийгээгүй мөнгөний ордын хувьд мөн 2-рт жагсаж байна. Харин 2001 онд нээсэн Оюу толгойн орд нь алт, зэснийн нөөцөөр хамгийн тои нь бөгөөд жилийн 450,000 тон зэсийн, 330,000 унц алтны нөөцтэй гэсэн тооцоо гаргаад байгаа билээ.

Монгол улсад үйлдвэрлэж байгаа уул уурхайн бүтээгдэхүүнийг дэлхийн үйлдвэрлэлттэй харьцуулбал, 2006 онд манай улс 131.1 мянган тонн зэс болон зэс агуулсан баяжмал үйлдвэрлэсэн нь дэлхийн хэмжээнд үйлдвэрлэсэн 15.4 сая тонн зэсийн 0.8%-ийг эзэлж байна.


График 3. 2006 оны дэлхийн зэс үйлдвэрлэлт. /улсаар/



Эх сурвалж: <http://www.mrpm.gov.mn/>

2006 оны дэлхийн зэс үйлдвэрлэлт. /улсаар/ Манай улс 2006 онд 350 мянган тонн жоншны баяжмал үйлдвэрлэсэн нь дэлхийн нийт үйлдвэрлэсэн 5.33 сая тонн жоншны 6.6%-ийг эзэлж дэлхийд жонш олборлолтоороо 3 дугаарт


График 4. 2006 оны дэлхийн жонш үйлдвэрлэлт. /улсаар/



Үг нэмэлт: <http://www.mrpm.gov.mn/>

Манай алтны үйлдвэрүүд 22561.3 кг (ҮСГ-ын эх сурвалжаар) алт олборлосон нь 2006 онд дэлхийн хэмжээгээр 2530 тонн алт үйлдвэрлэсний 0.9% болж байна.


График 5. 2006 оны дэлхийн алт үйлдвэрлэлт. /улсаар/



Үг нэмэлт: <http://www.mrpm.gov.mn/>


Эрдэнэт УБҮ 2006 онд 1400 тонн молибдени үйлдвэрлэсэн нь дэлхийд нийт 178.9 мянган тонн молибдени үйлдвэрлэсний 0.8%-ийг эзэлж молибдений үйлдвэрлэлтээрээ 10 дугаарт орж байна.

График 6. 2006 оны дэлхийн молибдени үйлдвэрлэлт. /улсаар/



Эх сурвалж: <http://www.mrpm.gov.mn/>

График 7. Алт олборлогч компаниуд




Эх сурвалж: <http://www.mrpm.gov.mn/>

Монгол улсын уул уурхайн салбар 2006 онд уламжлалт зэсийн баяжмал, молибдений баяжмал, жоншны баяжмал, бүхэллэг жонш, алт, нүүрс, катодын зэс, гянт болдын баяжмал, төмрийн хүдэр, давс, барилгын материалын түүхий эд үйлдвэрлэсэн бөгөөд бүтээгдэхүүний өсөлтийг сүүлийн жилүүдтэй харьцуулах зорилгоор 1997-2006 оны уул уурхайн бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг аж ахуйн нэгжүүд, Гаалийн ерөнхий газрын мэдээний дагуу дараах хүснэгтэнд, 1990-2006 оны жоншны бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг 4-р зурагт, зэс гаргалтын хэмжээг “-р зурагт, молибдений бүтээгдэхүүн гаргалтын хэмжээг 6-р зурагт, алт

гаргалтын хэмжээг 7-р зурагт тус тус Үндэсний статистикийн газрын мэдээллийн дагуу үзүүлэв.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2005 онд нийт экспортын бүтээгдэхүүний 75.8%-ийг эзлэж байсан бол 2006 онд 75.7%-ийг эзлэх болжээ.

График 8. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт.



Эх сурвалж: <http://www.mrpm.gov.mn/>

Алт олборлогч үйлдвэрүүдийн хувьд шороон ордын элс олборлолт, боловсруулалт бага зэрэг өсч үндсэн ордын хүдэр олборлолт, хүдэр боловсруулалт буурсан ч 2005 оны алт үйлдвэрлэлээс 3.8 хувь буюу 0.74 тн-оор өссөн байна.

Хүснэгт 1. Олборлолтын үйл ажиллагаа

Үзүүлэлт	Х/н	2005	2006	2006/2005
Аж ахуйн нэгжийн тоо	ш	131	127	-3.05%
Хөрс хуулалт	Сая.м ³	16.34*	63.34	287.64%
Элс олборлолт (шороон)	Сая.м ³	12.14	14.08	15.98%
Элс боловсруулалт	Сая.м ³	12.43	13.72	10.38%
Хүдэр олборлолт (үндсэн)	Сая.тн	4.06	2.96	-27.09%
Хүдэр боловсруулалт (үндсэн)	Сая.тн	4.04	2.65	-34.40%
Алт олборлолт (х.ц)	Кг	21900	21267	-2.89%
Борлуулсан алт (х.ц)	Кг	22788	17899	-21.45%

Эх сурвалж: <http://www.mrpm.gov.mn/>

2006 онд 116 шороон орд, 3 үндсэн орд, 9 үүсмэл ордоос алт олборлосон байна.

Алт олборлогч аж ахуйн нэгжүүдээс 1000 кг-аас илүү алт олборлож байгаа 3, 500-1000 кг алт олборлож байгаа 2, 100-500 кг алт олборлож байгаа 8, 50-100 кг алт олборлож байгаа 8, 50 кг-аас доош алт олборлож байгаа 105 байна.

Алт олборлолтын хэмжээгээр 2006 онд тэргүүлсэн 10 том аж ахуйн нэгжийг бусадтай нь харьцуулсныг 3.8-р зургаас үзэж болно.

Хүснэгт 2. Алт олборлолтоор тэргүүлэгч компаниуд 2006 он.

Алт олборлолтоороо 2006 онд тэргүүлж байгаа 10 аж ахуйн нэгжүүд:		
1	Бороо гоулд ХХК	52%
2	Алтандорнод Монгол ХХК	13%
3	Гацуурт ХХК	6%
4	Шижир алт ХХК	5%
5	Эм Жи Эйч ХХК	4%
6	Тосон алт ХХК	2%
7	Монполимет ХХК	2%
8	Жамп ХХК	1%
9	Улз гол хоршоо	1%
10	Дацантрейд ХХК	1%
11	Бусад аж ахуйн нэгжүүд нийт олборлолтын 13%-ийг эзлэж байна	1%

Эх сурвалж: <http://www.mrpam.gov.mn/>

III. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ОНОЛЫН АСУУДАЛ

Судлаачид компанийн нийгмийн хариуцлагын талаар өргөн хүрээтэй онолын судалгааг хийсэн.

Судалгааны үндсэн ухагдахуун нь компанийн нийгмийн хариуцлага юм. Carroll (1999) үзэж байгаагаар компанийн нийгмийн хариуцлага нь аливаа бизнесийн үүрэг ролийг нийгмийн хариуцлагатай уялдуулан судалдаг удирдлагын ухааны нэг чиглэл болно. Тэрээр компанийн нийгмийн

хариуцлагын загвартаа дөрвөн төрлийн үүрэг хариуцлагыг тодорхойлжээ. Үүнд:

- Ашиг орлоготой байх эдийн засгийн хариуцлага;
- Хуулийг дагаж мөрдөх эрх зүйн хариуцлага;
- Зөв юм хийх, үнэнч шударга байх ёс зүйн хариуцлага;
- Төрөл бүрийн олон нийтийн, боловсролын, соёлын болон спортын үйл ажиллагааг дэмжих сайн санааны хариуцлага зэргийг оруулжээ.

Эдгээр төрлийн компанийн нийгмийн хариуцлага нь компаниудын үйл ажиллагаа явуулж буй орон нутаг, нутгийн иргэдээс ихээхэн хамааралтай байдаг нь байгаль хамгааллын асуудал хурцаар тавигдах болсон, орон нутгийн хүмүүсийн амьдралын хэв маягт өөрчлөлт орж эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх хандлага зэрэгтэй холбоотой.

Kotler and Lee (2005) нар дэлхий дахинаа компанийн нийгмийн хариуцлагын асуудал хөгжиж байгаа гол шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Нийгэм, байгаль орчинд чиглэсэн хөтөлбөрийг явуулахад засгийн газрын үүрэг оролцоо багассан, нөөц хомсдсон болон хувийн ба олон нийтийн харилцааны шаардлага нэмэгдсэн;
- Компаниуд өөрийн ил тод нээлттэй, хариуцлагатай бодлогоор өндөр ур чадвартай ажилтнуудыг өөртөө татах, тогтвортой ажиллуулах сонирхол нэмэгдсэн;
- Компаниуд бизнесийн үйл ажиллагаандаа илүү санаа тавьж өөрсдийн байр суурийг хамгаалах, зах зээл дэх нэр хүндээ бэхжүүлэхэд анхаарах болсон;
- Нийгэмд хариуцлагатай байх бодлого нь ашиг орлогыг нэмэгдүүлэхэд таатай нөлөө үзүүлдэг;
- Технологийн дэвшлийн үр дүнд бизнесийг хэрхэн эрхэлж буй байдал нээлттэй, ил тод болж буй, бизнест ашиг сонирхлын олон янзын бүлгийг татан оролцуулах болсон зэрэг хүчин зүйлүүдээр тайлбарлажээ.

Зарим судлаачид Friedman-ы /1970/ тодорхойлсноор компанийн нийгмийн хариуцлагыг хувьцаа эзэмшигчийн ашгийг тоглоомын дүрмийн зарчмаар /шударга өрсөлдөөн, худал хуурмаг бус г.м/ нэмэгдүүлнэ гэсэн онолын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөг. Энэ үзэл баримтлал нь судалгааны бүтээлүүдэд компанийн нийгмийн хариуцлагыг хөдөлгөгч онол гэж нэрлэн захирлууд өмчийн эзний ашиг сонирхлыг хамгаалахад тэдний үүрэг хариуцлага оршино гэж тайлбарласан байна.

Сүүлийн үеийн онолоор Sternberg (1994) компанийн нийгмийн хариуцлагыг байгууллага өөрсдийн ашиг сонирхлын бүлгийн сонирхлыг хамгаалахын зэрэгцээ эдийн засгийн, байгаль орчинд тогтвортой байдлыг ханган үйл ажиллагаа явуулахыг хэлнэ гэж томъёолжээ.

Carroll (1999), Matten & Crane (2005), Porter & Kramer (2002), Porter & Lee (2005) нар компанийн нийгмийн хариуцлагын практик судалгаанд онцгой хувь нэмэр оруулж, компанийн нийгмийн хариуцлагын асуудалд даяаршлын үзүүлж буй үр нөлөөг тогтоон, хэрхэн үүрэг хариуцлага нь өөрчлөгдөж буй зарчмыг тодорхойлсон юм.

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь сонирхлын бүлгээ тодорхойлж тэдгээрийн хэрэгцээ, үнэт зүйлсэд нийцүүлж стратегийн болоод өдөр тутмын шийдвэр гаргалтын хүрээнд хийгддэг үйл ажиллагаа юм. Иймээс нийгэм, түүний дотор үйл ажиллагаагаа явуулж байгууллага хэдэн сонирхлын бүлгийн өмнө хариуцлага хүлээх ёстой вэ гэдэг нь шууд ба шууд бусаар наад зах нь үйл ажиллагааны салбар, нөгөөтэйгээр үйл ажиллагааны хэтийн төлөвөөс ихээхэн хамаардаг байна.

Компанийн нийгмийн хариуцлага хэмээх ойлголт нь компанийн ашиг орлогын тухай асуудлаас илүү хэтийг харсан зүйл бөгөөд энэ нь компаниуд өөрсдийгөө ёс зүйн үнэт зүйлс, ил тод байдал, ажиллах хүчиний харилцаа, хуулийг хэрэгжүүлж йл ажиллагаа явуулж орон нутгийн иргэдэд хүндэтгэлтэй хандах асуудал юм. Энэ нь хааяа хааяа орон нутгийн иргэдэд хандан явуулдаг арга хэмжээнээс илүү өргөн цар хүрээтэй зүйл бөгөөд компани стратеги шийдвэр гаргах, түншээ олох, ажилд авах, барааны тэмдгийг боловсруулахад чиглэсэн компанийн философи юм.²

Компанийн нийгмийн хариуцлагын асуудал нь бизнесийн ашиг орлогын асуудалд анхаарал тавихын зэрэгцээ сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, хариуцлага юм. Тодорхой нэг салбарт ажиллаж буй компанийн өдөр тутмын удирдлагын асуудалд эсвэл хувь хүн хууль дүрэм биелүүлэхтэй холбогдож үүсэх асуудлаас энэхүү хариуцлагын асуудал нь илүү өргөн цар хүрээг хамаарч байдаг бөгөөд хариуцлагаа ухамсарлахгүй, үүргээ биелүүлэхгүй байх нь хууль зөрчихөд хүргэнэ. Хуулийг сахих, түүний хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь байгууллагын ёс зүйн соёлыг илэрхийлсэн асуудал байдаг ч компанийн нийгмийн хариуцлагын асуудлын гол асуудал болдоггүй. Компанийн нийгмийн хариуцлагын асуудал нь бизнесийн стратеги иймээс ч түүнийг сонгож авах уу үгүй юу гэдгийг шийдэх алхам юм. Компанийн хувьд стратегийн давуу байдлыг олж авна гэсэн итгэл үнэмшил л компанийг нийгмийн өмнө хариуцлагатай байх сонголтод хүргэдэг. Энэ хариуцлага нь компанийн амжилтыг

² M. McComb, “Profit to be found in companies that care” South China Morning Post, April 14, 2002, p.5.

нэмэгдүүлэх, байгууллагын ирээдүйд чиглэсэн байгууллагын үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг мөн.

Нийгмийн хариуцлагын онолоор бизнесийн зорилго нь зөвхөн ашиг орлого олох бус юм. Энэ нь бизнес ямар нэг юм хийснээр аливааг сайжруулах, дээшлүүлэх байдлаар ашиг гаргахыг хэлнэ. “Ямар нэг” юм нь бизнесийн хувьд бизнес хийх шалтгаан болдогийн дээр бизнесийн нь ёс зүйн асуудалыг багтаана. Алдаа гаргах нь хэн нэгэнийг мөхөлд хүргэнэ. “Хэрэвээ бид оршин тогтнож чадахгүй бол, бид юугаа бүтээх билээ?” “Зөвхөн бид ямар нэг юмыг сайн хийж, хүн бүхэнд ашигтай үр дүн авчирч чадаж л байвал томоохон барианд хүрнэ”.³

Өндөр хөгжсөн улс орнуудын хувьд компанийн нийгмийн хариуцлагыг дараах асуудалд анхаарлаа хандуулан хэрэгжүүлж байна:

- Компанийн засаглал
- Эх оронч үзэл
- Шударга худалдаа
- Олон төрөлт бизнес
- Компанийн барааны тэмдэг.

Heledd Jenkins (2003) уул урухайн компаниудын үйл ажиллагаа ба байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн хооронд үүсч буй зөрчлийн асуудлыг судлан, уг асуудал хэрхэн компанийн нийгмийн хариуцлагын стратегид нөлөөлсөнийг кэйс дээр үзүүлжээ.

Hamann R (2002) Өмнөд Африкийн жишээн дээр бизнесийн онолын үүднээс уул уурхайн тогтвортой хөгжлийн асуудал дахь үүргийг тайлбарласан байна. Түүний тайлбарласнаар бизнесийг үзэх үзэл бодлын өөрчлөлтийн улмаас компаниудын байгаль орчны болон нийгмийн хариуцлага нэмэгдэж, зөвхөн хандиваар хязгаарлагдахгүй болж, Засгийн газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг болсон байна.

Gavin Hilson and Barbara Murck (2000) уул уурхайн компани ба тогтвортой хөгжлийн асуудлыг судалж, уул уурхайн компани хэрхэн тогтвортой үйл ажиллагаа явуулах аргачлалыг боловсруулжээ.

Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн консул (World Business Council for Sustainable Development/WBCSD) нийгэм, орон нутгийн хөгжил, компанийн ажилчид, тэдний гэр бүлийн амьдралыг дээшлүүлэх замаар эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, ёс зүйтэй үйл ажиллагаа

³ Charles Handy, “What’s a Business For? Harvard Business Review, Vol. 80, No 12, December 2002, pp49-55

явуулах үүрэг хариуцлагыг компанийн нийгмийн хариуцлага гэж тодорхойлжээ (WBCSD Stakeholder Dialogue on CSR, The Netherlands, Sept 6-8, 1998). Дэлхийн тогтвортой хөгжлийн бизнесийн консулын тодорхойлсоноор компанийн нийгмийн хариуцлага нь 7 асуудлыг багтаадаг ажээ. Үүнд:


- Хүний эрх
- Ажилчдын эрх
- Байгаль орчны хамгаалал
- Орон нутгийн оролцоо
- Ханган нийлүүлэгчтэй харилцах харилцаа
- Хяналт шалгалт
- Ашиг сонирхлын бүлгийн эрх.

David Cavett Goodwin (2007, Making the case for corporate social responsibility) компанийн нийгмийн хариуцлага нь зөвхөн мөнгө зарцуулах төдийгүй нягтлан бодох бүртгэл /снахүүгийн үйл ажиллагааны ил тод байдал/, компанийн үйл ажиллагааны нийгэм, байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ гэжээ. Goodwin нийгмийн хариуцлагын хэлбэр болон үе шатыг Sethi-н үе шатны схемийг ашиглан гаргажээ.

Хүснэгт 3. Нийгмийн хариуцлагын гурван үе шат

Нийгэмд хүлээх үүрэг доогуур	Нийгэмд хариуцлагатай	Биелэлт өндөр
Мэдэрдэг Бага зэрэг ухамсарладаг	Хэрэгжүүлдэг Хуулинд зааснаас арай илүү зүйлийг хийдэг	Идэвхтэй, эерэгээр авч үздэг Асуудлыг урьдчилан харж, арга хэмжээ авдаг
Хуулийн заалтыг хэрэгжүүлдэг	Эдийн засгийн асуудлаас илүүг хийдэг	Нийгэмд хариуцлагатай санаа, үйл ажиллагааг эрж хайдаг
Эдийн засгийн асуудлыг авч үздэг	Олон нийтийн шүүмжийг тойрч гарахыг оролддог	Олон нийтийн саналыг авч үздэг

График 9. Нийгмийн Хариуцлага



Эх сурвалж: A Guide to Corporate Social Responsibility. URL: www6.miami.edu/ethics/pdf_files/csr_guide.pdf

IV КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН КЕЙС

Компанийн нийгмийн хариуцлагын талаархи томоохон аж ахуйн нэгжээс гаргадаг тайланг судалгаанд ашиглаж өнөөгийн компанийн нийгмийн хариуцлагын байдлын бодит дүр зургийг харах зорилгоор доор дурьдсан компаниудаас олон нийтэд зориулж гаргасан тайланг ашигласан.

Тайлангаас үзэхэд компаниуд олборлолтын дараа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу Монгол улсын стандартын дагуу хийгдэж тодорхой төсвийг зарцуулдаг болох нь харагдлаа. Мөн нийгмийн хариуцлагын бүрэлдэхүүн хэсэгт орох хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажлын орчин нөхлийг хангах, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, нийгэм, соёлын арга хэмжээг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанууд хийгдэж явдаг нь тодорхой байна. Эдгээр үйл ажиллагаанд компаниу төсөв санхүүгийнхээ нэлээд хувийг зарцуулж цаашид ч зарцуулах төлөвлөгөөтэй байгаа нь тайлангаас харагдаж байна.

Сонгон авсан томоохон аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагын байдал дараахи байдалтай байна./ Хүснэгт 4/

Хүснэгт 4. Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын нийгмийн хариуцлагын өнөөгийн байдал

Гадаадын Хөрөнгө оруулалттай Уул уурхайн компаниуд	Бороо Гоулд ХХК	Эрдэнэт УБҮ	Монросцветмет	Вагнер Ази	Дарханы төмөрлөгийн үйлдвэр
Мэдээллийн эх сурвалж					
Нийгмийн хариуцлагын тайлан	✓	✓	✓	✓	✓
Вэбсайт	✓	✓	✓	✓	✓
Компанийн нийгмийн хариуцлагын бодлого					
Хэрэгжүүлж буй бодлого					
компанийн түвшин		✓		✓	
уурхайн түвшинд					
Ажиллагсад					
Орон нутгийн иргэдийг ажилд авах эрмэлзэл	✓			✓	
Хөдөлмөр эрхлэлтэд анхаарал тавих байдал, сургалт явуулдаг эсэх			✓		✓
Ажиллагсдын нийгмийн хариуцлагын талаархи мэдлэгийг дээшлүүлдэг эсэх	✓	✓	✓		✓


Шударга цалин хөлсний бодлого, орон нутгийн эдийн засагт оруулдаг хувь нэмэр					
Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх байдал	✓	✓			✓
Ажилагсдын сайн дурын үйл ажиллагаа, буяны үйлсийг дэмжи байдал					
Олон улсын хөдөлмөрийн 155 конвенци (ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал)	✓	✓	✓		✓
Орон нутгийн иргэд					
Орон нутгийн асуудлыг байнга мэдэрч шийдвэрлэх байдал	✓	✓			
Ажилчдад зориулсан орон нутгийн соёл уламжлалийн талаархи сургалт					
Орон нутгийн иргэдийн амьдрал, орон нутгийг хөгжүүлэх асуудлаар төсөл боловсруулах асуудлаар зөвлөлддөг эсэх	✓				
Орон нутгийн амьдралд оруулах хувь нэмэр (сургууль, эмнэлэг г.м)	✓	✓	✓	✓	✓
Орон нутагт хэрэгжиж буй төслийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг хангах асуудлаар орон нутгийн иргэдийг сургадаг эсэх					
ТББ ба Төрийн байгууллага					
Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах байдал					
Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллах байдал					
Хүн ам					
Мэдээллийг нээлттэй түгээх байдал (вебсайт)	✓	✓	✓	✓	✓
Сонин гаргаж, сэтгүүлд нийтлүүлэх					
Соёл урлаг, боловсролыг ивээн тэтгэх	✓	✓	✓	✓	
Нийгмийн бодлогыг хэрэгжүүлсэн тухай зардлын тайлан	✓	✓	✓	✓	✓
Нийгэмд оруулсан хувь нэмэрийг санхүүгийн дэмжлэгээс бусад хэмжүүрээр					
Буяны сан, хуримтлалтай эсэх					
Байгаль орчин					
Байгаль орчны менежмент байгаа эсэх	✓	✓	✓	✓	✓
Байгаль орчны талаар хий буй үйл ажиллагаагаа байнга мэдээлж аудит хийдэг эсэх	✓				
Урт хугацааны байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөтэй эсэх	✓		✓		

V. ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ

Нийт 1040 санал асуулгын хуудсыг олон нийтийн дунд тараасан. Үүнээс 600 хариулагч буюу нийт санал асуулгад оролцох хариулагчийн 57.7 хувь нь оролцжээ. Хариулагчийн 70,8 хувь нь 18-40 настай, 26,2 хувь нь 41-60 настай байсан ба зөвхөн 3 хувь нь 60-аас дээш настай байв. Нийт хариулагчийн хувь нь 301 буюу 50,2 хувь нь эрэгтэй, 299 нь буюу 49,8 хувь нь эмэгтэй байна.


Түүвэрт Улаанбаатар, Баянхонгор, Эрдэнэт, Сэлэнгэ, Өвөрхангай, Багануур, Налайх, Дарханы хүмүүс оролцжээ.

График 10. Хариулагчийн орон нутгийн харьяалал




Хариулагчдын 17,3 хувь нь төрийн байгууллагад, 16 хувь нь хувийн компанид ажиллаж байна. Үлдсэн хувь нь хамтарсан компани, иргэний нийгэмд, орон нутгийн засаг захиргаанд ажилладаг байна. 36 хувь нь тухайн орон нутагт амьдардаг хүмүүс ажээ.

График 11. Хариулагчийн эрхэлж буй ажил




Та компанийн нийгмийн хариуцлагын талаар хэр зэрэг мэдлэгтэй вэ гэсэн асуултанд хариулагчдын 15 орчим хувь нь компанийн нийгмийн хариуцлагын талаар маш сайн мэднэ гэж хариулжээ. Харин 31,9 хувь нь энэ асуудлын талаар нэдээд сонсч мэддэг болсон гэсэн бол 28,2 энэ талаар сүүлийн үед л сонсох болсон гэж хариулжээ. Хариулагчдын 18 хувь асуудал сонссон төдий л байна гэж хариулсан бол зөвхөн 8 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График 12. Та компанийн нийгмийн хариуцлагын тухай хэр зэрэг мэдэх вэ?



Бизнесийн байгууллагад нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын асуудал улам бүр ач холбогдолтой болж байгаа талаархи хүмүүсийн ойлголтыг асуухад өрсөлдөөн нэмэгдэх тутам чухал болж байна (344), дэлхий нийтээр анхаарлаа хандуулах болсон (343) бизнесийн урт хугацааны оршин тогтноход чухал хүчин зүйл (318). Түүнчлэн, нийгмийн зүгээс бизнест тавих шаардлага хатуу болсон тул чухал гэсэн 259 хариулт, даяаршил, мэдээллийн чөлөөт урсгалын улмаач ач холбогдолтой гэсэн 199 хариулт байна.

График 13. Бизнесийн байгууллагад нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын асуудал улам бүр ач холбогдолтой болж байгаагийн учир




Санал асуулгад оролцогчдын 10 орчим хувь нь гадаадын компаниудаас суралцах сайн туршлага, зүйлс дотоодын компаниудад их бий гэдгийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд 60 гаруй хувь нь үүнтэй санал нэг байна. Зөвхөн 12,5 хувь нь үүнтэй санал нийлэхгүй байгаа ба 3,4 хувь нь огт хүлээн зөвшөөрөхгүй байна. .

Нийт 599 санал асуулгад оролцогч гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд орон нутагт ажлын байр бий болгодог гэж үзэж байна. Хариулагчийн 60 гаруй хувь нь үүнтэй санал нэг байгаа боловч орон нутгийн засаг захиргааны ажилтнууд уг саналыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Хувийн компанийн ажилтнууд ч үүнд нэг их итгэлтэй бус байна. Орон нутгийн засаг захиргааны ажилтнуудын 53 хувь нь ажлын байр бий болдог гэж үзэж байгаа боловч 27 хувь нь ажлын байр бий болгодоггүй гэж үзэж байна. Харин тэдний 20 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.


Төрийн байгууллагын ажилчдаас бусад бүх салбарт ажиллагчид гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг цалин хөлсний шударга тогтолцоотой гэж үзэхгүй байна. Төрийн байгууллагын ажилчидын санал дөнгөж 57 орчим хувь байгаа нь уг саналын талаар тийм ч их итгэлтэй байгаа гэсэн үг бас ч биш юм. Иргэний нийгмийн болон хамтарсан үйлдвэрт ажилладаг хүмүүс уг саналд хамгийн бага оноо өгчээ. Тухайлбал хамтарсан үйлдвэрт ажилладаг хүмүүсийн 49 хувь нь уг саналыг дэмжихгүй байгаа бөгөөд 13.3 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Нийт хамтарсан үйлдвэрт ажил эрхэлдэг хүмүүсийн 37 хувь нь шударга цалин хөлсний тогтолцоотой гэж үзэж байна.

График 14. Цалин хөлсний шударга тогтолцоотой




Хариулагчид бүгд гадаадын компаниудад ажиллахад ажлын байран дээр суралцах боломж бүрэн бий гэжээ. Нийт хариулагчдын 48 хувь нь уг саналыг бүрэн дүүрэн дэмжиж байна. Харин 30.5 хувь нь санал нэгтэй байна.

График 15. Байгууллагын ажилтны хувьд ажлын байран дээр шинэ зүйлд суралцах боломж их бий




Хариулагчдын бүх төлөөлөл уг саналыг дэмжээгүй бөгөөд хамгийн бага оноог хамтарсан үйлдвэрийн ажилтан, иргэний нийгмийн төлөөлөл уг асуудалд хамгийн доогуур оноог өгчээ. Хамтарсан үйлдвэрт ажилладаг хүмүүсийн 50-аас илүү хувь нь гадаадын компаниудын эрүүл ахуй, аюулгүй байдал хангалтгүй гэж үзэж байгаа бөгөөд 20 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График 16. Гадаадын компаниудад ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал баталгаатай.




Гадаадын компаниудын бизнесийн ёс зүй өндөр гэдэгтэй хамтарсан үйлдвэрийн ажилтнууд болон хувийн компанийн ажилтнууд санал нэгдэхгүй байна. Харин орон нутгийн иргэд, төрийн байгууллагын ажилтнууд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид, иргэний нийгмийн төлөөлөгчдийн хариултыг жигнэж үзэхэд дунджаар 56-59 хувьтай байгаа нь уг асуудалтай ерөнхийдөө санал нэгтэй байна гэсэн үг юм.

График 17. Бизнесийн ёс зүй өндөр байдаг




Хариулагчдын бүх төлөөлөл гадаадын компаниудыг үйл ажиллагаагаа ил тод мэдээлдэг гэж үзэхгүй байна.

График 18. Гадаадын компаниуд үйл ажиллагаагаа ил тод мэдээлдэг.



Хариулагчид гадаадын хөрөнгө оруулалт улс орны эдийн засгийн хөгжил, шинэ технологи, мэдлэг нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн хөгжил, дэд бүтийн хөгжилд хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Харин байгаль орчныг зөв зохиостой ашиглах туршлага нэвтэрнэ гэж бодохгүй байгаа бөгөөд нийгмийн салбарын хөгжил, ядуурал ажилгүйдэл буурна гэдэгт арай бага итгэлтэй байна.

График 19. Гадаадын хөрөнгө оруулалт ямар сайн зүйлийг авчирч байна вэ?



Ерөнхийдөө хариулагчид гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд ашигт малтмалын нөөцийг зохиостой ашигладаг тэргүүн туршлага нэвтрүүлдэггүй гэж үзжээ. Ялангуяа хамтарсан компанийн төлөөлөл тэргүүн туршлага нэвтрүүлдэггүй гэдгийг багтай хэлж байна. Орон нутгийн засаг захиргааны


төлөөлөл, хувийн компанийн төлөөлөл, орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид мөн адил санал бодолтой байна.

График 20. Ашигт малтмалын нөөцийг зохистой ашигладаг тэргүүн туршлага нэвтрүүлдэг




Санал асуулгад оролцогчид төрийн албан хаагчдаас бусад оролцогчид компаниуд ядуурлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаггүй гэж үзсэн байна. Хувийн бизнесийн төлөөлөл ядуурал бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа огт байдаггүй гэсэн байна.

График 21. Ядуурлыг бууруулах үйл ажиллагаа




Хариулагчид ерөнхийдөө гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ил тод үйл ажиллагаа тааруу байдаг гэж хариулжээ. Хамтарсан компанийн төлөөлөл ч ил тод байдал хангалтгүй байдаг гэсэн байна. Төрийн албан хаагчид, хувийн компанийн ажилтнууд, орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл ч мөн ижил санал бодолтой байна.

График 22. Ил тод байдал



Санал асуулгад оролцогчид нийтээрээ гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байгаль орчинд нөлөөлөлгүй үйл ажиллагаа явуулдаг гэдэгтэй санал нийлэхгүй байна. Төрийн бус байгууллагын оролцогчийн нэгэн адил хамтарсан болон хувийн компанийн төлөөлөлүүд ч санал нэгтэй байлаа.

График 23. Байгаль орчинд нөлөөгүй үйл ажиллагаа



Гадаадын хөрөнгө оруулалттай компанудын олон нийттэй харилцах харилцаа, орон нутагт үзүүлэх үйлчилгээг хангалтгүй байдаг гэж үзжээ. Төрийн бус байгууллага, хамтарсан компани, орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид ч мөн адил санал бодолтой байна.

График 24. Олон нийттэй харилцах харилцаа, орон нутагт үзүүлэх үйлчилгээ



Судалгаанд оролцогчид нийтээрээ гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын буяны үйл ажиллагааг хангалтгүй гэж үзсэн байна. Санал асуулгад оролцогчдын санал бодол төдийлөн их зөрүүгүй байлаа.

График 25. Хандив, буяны үйлс



Санал асуулгаас гарсан үр дүн

- Хариулагчид компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг сүүлийн үед сонсч мэдэх болсон зүйл гэж хэлж байна. Орон нутгийн иргэд, хамтарсан компанийн ажилтнууд, хувийн компанийн ажилтнууд бусад санал асуулгад оролцогчидтой харьцуулахад илүү мэдлэгтэй нь харагдаж байна.
- Санал асуулгад оролцогчид компани нийгмийн өмнө хариуцлагатай ажиллах болсныг өсөн нэмэгдэж байгаа өрсөлдөөн, дэлхий нийтээр энэ

асуудалд анхаарлаа хандуулах болсон, бизнес урт хугацаанд оршин тогтнох эрмэлзэл зэргээр тайлбарласан байна.

- Хариулагчид гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засаг өсөлт, шинэ технологи нэвтрүүлэх, нийгмийн салбарыг хөгжүүлэх хувь нэмэр, хүний нөөцийг чадавхижуулах хүчин зүйл гэж үзэж байна.
- Орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид дотоодын компаниуд гадаадын компаниудын туршлагаас суралцаж өөрсдийн бизнесийн хөгжүүлэх боломжтой гэж үзсэн байна.
- Гадаадын компаниудын цалин хөлсний шударга тогтолцооны талаар янз бүрийн бодолтой байна. Төрийн албан хаагчдаас бусад санал асуулгад оролцогчид гадаадын компаниуд шударга цалин хөлсний тогтолцоотой байдаг гэдэгтэй санал нийлэхгүй байна. Ажлын байран дээр суралцах боломжийн талаар зөвхөн хамтарсан компанийн төлөөлөгчид хүлээн зөвшөөрсөн бол бусад хариулагчид энэ асуудалд сөрөг байр суурьтай байлаа.
- Хариулагчдийн дийлэнхи олонхи нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд бизнесийн ёс зүй өндөртэй байдаг гэсэн бол, харин хамтарсан компанийн төлөөлөгчид үүнтэй санал нийлэхгүй байлаа.
- Хувийн компани, хамтарсан компаниудын төлөөлөл гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ил тод үйл ажиллагаа явуулдаг гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй байна. Мөн орон нутгийн иргэд, төрийн албан хаагчид ч энэ байдлыг хүлээн зөвшөөрөөгүй байна.
- Хариулагчидийн дийлэнхи олонхи гадаадын хөрөнгө оруулалттай компани нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг гэдэгтэй санал нэгдэж байна.
- Санал асуулгад оролцогчид гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд байгалийн нөөцийг байгаль орчинд хор хөнөөлгүй ашигладаг тэргүүн туршлагаас нэвтрүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй байна.

Хүснэгт 5. Компанийн нийгмийн хариуцлагын талаархи Олон нийтийн санал бодлыг харьцуулах нь

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд	Орон нутгийн төлөөлөл
<i>Өдөр тутмын үйл ажиллагаа (байгаль орчны тэнцвэртэй байдал, ажлын байрны асуудал)</i>	
- Компаниуд нөхөн сэргээх үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулдаг хэдий ч тэр бүр үр дүнтэй биологийн нөхөн сэргээлт хийдэггүй	- Орон нутгийн иргэд байгаёу хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хангалтгүй гэж үзсэн - Компаниудын цалингийн тогтолцоо төдийлөн сайнгүй байдаг - Цөөн хэдэн хариулагчид

<ul style="list-style-type: none"> - Компаниуд ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалт хийдэг - Цөөн тооны байгууллага цалинтай дүйцэх урамшуулалтай - Цөөн компани ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайтар хангадаг 	<p>хөдөлмөр эрхлэлтийн асуудал нь хангалттай сайн гэж үзсэн</p>
<p><i>Ёйиàíéí çàñàäëä, èè òüü ààéäè àà íëü íéèðèéí òüüàèð</i></p>	
<ul style="list-style-type: none"> - Зөвхөн томоохон хэдэн компанийн өөрсдийн нийгмийн хариуцлагын тайлан гаргаж олон нийтэд мэдээлдэг 	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн иргэд компаниуд ил тод үйл ажиллагаа явуулдаг гэдгийг зөвшөөрөхгүй байна.
<p><i>Ёс зүй (хувь хүний болон хуулийн өмнө хүлээсэн хариуцлага)</i></p>	
<ul style="list-style-type: none"> - Компанийн төлөөлүүд хуулийн чанд сахидаг гэж үзэж байна. 	<ul style="list-style-type: none"> - Ёс зүй өндөр байдагтай санал нийлэхгүй байна.
<p><i>Орон нутгийн үйл ажиллагаанд оролцох байдал</i></p>	
<ul style="list-style-type: none"> - Зарим компаниуд орон нутагт тохирсон төслийг л хэрэгжүүлдэг - Олонхи нь засварын ажил санхүүгийн туслалцаа үзүүлдэг - Цөөн байгууллага дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийдэг 	<ul style="list-style-type: none"> - Тэр бүр үр дүнтэй үйл ажиллагаа өрнүүлдэггүй - Орон нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулдаггүй
<p><i>Хууль хэрэгжүүлэх байдал</i></p>	
<ul style="list-style-type: none"> -Хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг 	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн иргэд энэ асуудлыг хангатгүй байдаг гэж үзсэн
<p><i>Ашиг сонирхлын бүлгийн харилцаа (дотоод ба гадаад)</i></p>	

- Компаниуд нийлүүлэгчид, хэрэглэгчид, төрийн байгууллагуудтай сайн харилцаж ажилладаг	- Санал бодол ялгаатай байв. Зарим сайн харилцаатай ажилладаг гэж үзсэн бол нөгөө хэсэг нь эсрэг байр суурьтай байв
<i>Өдгөө, аяны үйлс</i>	
- Зарим нэг компани хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд дэмжлэг үзүүлдэг	- Байдаггүй гэж үзсэн

VI. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

Бизнесийн байгууллагууд компанийн нийгмийн хариуцлагын талаар хангалттай мэдлэггүй байдгаас өөрсдийн үйл ажиллагааг жижиг хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төдийхнөөр хязгаарладаг байна. Компаниуд ажилтнуудаа сургалт явуулдаг хэдий ч дийлэнхи олонхи нь эрүүл ахуй, аюулгүйн горимд ач холбогдол өгдөггүй нь харагдаж байна. Компани ажилтнууд ч хөдөлмөрийн хөлс, цалинтай тэнцэх орлого хангалтгүй, шударга бус байдаг гэж үзэж байна.

Компаниуд ямар нэг байдлаар өөрсдийн нийгмийн хариуцлагын тайланг вебсайт дээр байрлуулж мэдээлдэг ч тайлан тэр бүр олон нийтийн хүртээл болдоггүй байна.

Хэдийгээр компаниуд олон нийттэй сайн харилцдаг гэж үзэж байгаа ч олон нийт үүнийг мэддэггүй эсвэл компани олон нийтийн харилцааг үнэлэдэггүй байна. Үүнээс үүдэн компанийн нийгмийн хариуцлагын стратегийн чухал шийдвэр гаргахад олон нийтийг ороцлуулах асуудал байдаггүй байна. Боловсролын хөрөнгө оруулалт зэрэг компанийн зүгээс явуулдаг буяны үйл ажиллагааг олон нийт хангалтгүй байдаг гэж үзжээ. Ашиг сонирхлын бүлгийн харилцааг явуулдаг ч аль талуудтай сайн харилцаатай байдаг нь тодорхойгүй байна.

Компанийн нийгмийн хариуцлагын тухай олон нийтийн ойлголт өсч байна гэдэг нь компанийн стратегийн хөгжилд энэхүү асуудал нь улам бүр ач холбогдолтой болох нь харагдаж байна. Компаниуд өөрсдийн ажилтнуудад компанийн нийгмийн хариуцлагын талаархи мэдлэгийг дээшлүүлж, орон нутгийн иргэдэд өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдрүүлэх шаардлагтай байна.

Дэлхийн тогтвортой хөгжлийн олон улсын бизнесийн консулаас тодорхойлсон хүний эрх, ажилтны эрх, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн үйл ажиллагааны оролцоо, нийлүүлэгчийн харилцаа, ашиг сонирхлын бүлгийн эрх, мониторинг зэрэг асуудлыг ул суурьтай судлах шаардлага байна. Судалгаа нь тодорхой нэг асуудлыг бус харин асуудлыг өргөн хүрээтэйгээр олон улсын конвенци, тунхаглал, Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалд заасан хүний эрх, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн зарчим, эрхийн асуудлуудтай холбон судлахад чиглэвэл зохистой байна.

Ашигласан ном зүй.

1. Benn, Suzanne., (2007) **Corporate Governance and Sustainability: Challenges for Theory and Practice**, London ; New York: Routledge
2. Bomann-Larsen, Lene., (2004) **Responsibility in World Business: Managing Harmful Side-Effects of Corporate Activity**, United Nations University Press
3. Carroll A.B., (1999) **Corporate Social Responsibility-Evolution of a Definitional Construct**, Business and Society, 38
4. **Corporate Social-Responsibility and Environmental Management**. Wiley, <http://alias.libraries.psu.edu/ERESOURCES/WILEYINTERSCI>
5. David Cavett Goodwin (2007) **Making the case for corporate social responsibility**. 2007
6. Epstein, Marc J., (2008) **Making Sustainability Work: Best Practices in Managing and Measuring Corporate Social, Environmental and Economic Impacts**, Berrett-Koehler Publishers
7. Gavin Hilson and Barbara Murck (2000) **Sustainable Development in the Mining Industry: Clarifying the Corporate Perspective**. Resources Policy, Volume 26, Issue 4, December 2000.
8. Hamann R., (2003) **Mining Companies' Role in Sustainable Development: The 'Why' and 'How' of Corporate Social Responsibility from a Business Perspective**. Development Southern Africa, Volume 20, Number 2, June 2003
9. Hamilton, Michael S., (2005) **Mining Environmental Policy: Comparing Indonesia and the USA**. Aldershot, England ; Burlington, VT: Ashgate
10. Heledd Jenkins., (2002) **Corporate Social Responsibility and the Mining Industry: Conflicts and Constructs**. European Management Journal, Volume 20, Issue 2, April 2002
11. Heledd Jenkins, **Corporate Social Responsibility and the Mining Industry: Conflicts and Constructs**, Cardiff University, Wales, UK

12. Hilson, Gavin M., (2006) **Small-scale Mining, Rural Subsistence and Poverty in West Africa.**, Practical Action Publishing
13. Jones, Tim., (1992) **Environmental Impact Assessment for Coal.** London : IEA Coal Research
14. L.R. Jones, John H. Baldwin. (1994) **Corporate Environmental Policy and Government Regulation.**, Greenwich, Conn. : JAI Press.
15. Logsdon, J., and Wood, D. J. 2002. **Business Citizenship: From Domestic to Global Level of Analysis.** *Business Ethics Quarterly*, 12: 155–88.
McAdams, R., and Nadler, J. 2005. ‘Testing the Focal
16. Makower, Joel, (2000) **The Mentoring Handbook- A Guide to Environmental Mentoring for Companies, Nonprofits, and Regulators.** National Environmental Education & Training Foundation, Institute for Corporate Environmental Mentoring. URL
<http://www.neetf.org/pubs/handbook.pdf>
17. Matten D. and Crane, A. (2005) **Corporate Citizenship: Toward and Extended Theoretical Conceptualisation.** *Academy of Management Review*, 30/1
18. Mineral Resources an Petroleum Authority of Mongolia URL:
<http://mrpam.gov.mn/>
19. Ministry of Mineral and Energy of Mongolia URL:
<http://www.mfe.energy.mn/>
20. Ministry of Nature and Environment <http://www.mne.mn/>
21. Mongolian National Mining Association URL:
<http://www.miningmongolia.mn/en/>
22. North, Liisa., (2006) **Community Rights and Corporate Responsibility : Canadian Mining and Oil Companies in Latin America.**, Between the Lines, 2006
23. Otto, James., (2000) **Sustainable Development and the Future of Mineral Investment.** Paris, UNEP
24. Paul Kapelus , (2002) **Mining, Corporate Social Responsibility and the "Community"**: The Case of Rio Tinto, Richards Bay Minerals and the Mbonambi, *Journal of Business Ethics*, Netherlands, Volume 39, Number 3 / September, 2002
25. Porter, M and Cramer, M., (2002) **The Competitive Advantage of Corporate Philanthropy.** *Harvard Business Review*, December

26. Prospectors and Developers Association of Canada, (2007) **Sustainable Development and Corporate Social Responsibility: Tools, Codes and Standards for the Mineral Exploration Industry**
27. S.E. Church, T.S. Schmidt, C.A. San Juan, and G.S. Plumlee., (2007) **Effects of Mining on the Environment, a National Overview**. U.S. Geological Survey. NRDAR Conference. April 25, 2007
28. URL: http://pubs.usgs.gov/of/2007/1165/pdf/of07-1165_508.pdf
29. Smith, Mark J. and Piya Pangsapa., (2008) **Environment and Citizenship: Integrating Justice, Responsibility and Civic Engagement**. London and New York, Zed Books
30. Strellec, Kristen L., (2000) **Economic and Environmental Impact Assessment of Proposed Effluent Limitations Guidelines and Standards for the Coal Mining Industry: Remining and Western Alkaline Subcategories**. Engineering and Analysis Division, Office of Science and Technology, U.S. Environmental Protection Agency. URL <http://www.epa.gov/guide/coal/impact.pdf>
31. Yakovleva, Natalia., (2005) **Corporate Social Responsibility in the Mining Industries.**, Ashgate Publishing Co.
32. Van Zyl, Dirk J. A., (1992) **Risk Assessment/Management Issues in the Environmental Planning of Mines**. Society for Mining, Metallurgy, and Exploration
33. Woolfson, Charles, (2005) **Corporate Social Responsibility Failures in the Oil Industry**. Baywood Pub
34. Zarsky, Lyuba., (2002) **Human Rights and the Environment: Conflicts and Norms in a Globalizing World.**, Earthscan
35. Zumbansen, P. Forthcoming. **The Conundrum of Corporate Social Responsibility: Reflections on the Changing Nature of Firms and States**. In R. Miller and R. Bratspies (Eds.), *Transboundary harm: lessons from the Trail Smelter Arbitration*. Cambridge, England: Cambridge University Press.
36. www.pmis.gov.mn
37. http://mrpam.gov.mn/index.php?option=com_content&task=blogcategory&id=55&Itemid=83
38. <http://www.mfe.energy.mn/>
39. http://www.mne.mn/index.php?option=com_content&task=blogcategory&id=157&Itemid=86
40. <http://www.mnud.gov.mn/>